

# ДАВААН БУЛАГ ХК

Add: Ulaanbaatar, Mongolia Bayangol district,  
Peace avenue-28 P.O.B-35/283  
Tel: 976-99119114, Fax: 976-11-305421  
E-mail: davaan\_bulag@yahoo.com

2020.02.17

№ 20/1

Улаанбаатар хот

## ДАВААНБУЛАГ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарлахгүй  
байх тухай

" Даваанбулаг " ХК нь 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг үндэслэн 2020 онд ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА :



/ В.БАТТУЛГА /

# “ДАВААНБУЛАГ” ХК

2020 оны 03 дугаар сар 10 өдөр

№ 20/2

Улаанбаатар хот

## “ДАВААНБУЛАГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн  
хурлыг зарлан хуралдуулах тухай*

“Даваанбулаг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах талаар хэлэлцэж олонхийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даваанбулаг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Улаанбаатар хотод Астра худалдааны төвийн 2-р давхарт 2020 оны 04 сарын 22-ны өдөр 14 цагт хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доорхи асуудлыг хэлэлцэхээр баталсугай.
  - 2.1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх.
  - 2.2. ТУЗ болон ГУ-ын 2020 оны ажлын тайлан хэлэлцэх
  - 2.3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
  - 2.4. 2020 оны зорилтыг батлах
  - 2.5. ТУЗ болон ГУ-ын 2020 оны зардлын төсөв батлах
  - 2.6. Ногдол ашиг хувиарлахгүй байх ТУЗ-ийн 20/1 тоот тогтоолыг хэлэлцэх.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 03 сарын 30-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2020 оны 03 сарын 16-ний өдөр, 2020 оны 04 сарын 01-ны өдрүүдэд хурлын зар түгээх СЗХ-ны журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 01-р хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд танилцуулах материалын жагсаалтыг 02-р хавсралтаар, санал авах хуудсын загвар, агуулгыг 03-р хавсралтаар, Хурлын зарын загварыг 04-р хавсралтаар баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай “Масдак ҮЦК” ХХК -ийн байранд ажлын өдрүүдэд 09-16 цагийн хооронд танилцаж болохоос гадна өөрийн харилцдаг брокер дилерийн компаниар дамжуулан танилцаж болохыг дурьдсугай.
7. Санал авах хуудсыг хүлээн авах элчийн хугацааг 2020 оны 04 дугаар сар 21 –ний өдрийн 14 цаг байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулах комиссын даргаар Г. Дагиймаа, гишүүнээр Ш. Сүглэгмаа нарыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар У. Мягмарсүрэн, гишүүнээр Т. Оюунцэцэг нарыг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар В. Баттулгыг, нарийн бичгийн даргаар Д. Дэлгэрсайхан нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: **В. БАТТУЛГА**



# ДАВААН БУЛАГ ХК

Add: Ulaanbaatar, Mongolia Bayangol district,  
Peace avenue-28 P.O.B-35/283  
Tel: 976-99119114, Fax: 976-11-305421  
E-mail: Dawaanbulag@gmail.com

2020.04.22

№ 20/3

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн 2019 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлангийн тухай*

"Даваанбулаг" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон тогтоох нь:

1. "Даваанбулаг" ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2020 оны төлөвлөгөө зорилтыг баталсугай.
3. 2020 оны ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/ В.БАТТУЛГА /

# “ДАВААНБУЛАГ” ХК

2020 оны 04 дугаар сар 22 өдөр

№ 20/4

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалтыг удирдлага болгон “Даваанбулаг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас олонхийн санал авсан

Ердийн гишүүдээр:

1. М.Золжаргал
2. Ж.Мөнхбаяр
3. Б.Баянмөнх
4. Г.Батхуяг
5. Д.Түмэннасан
6. А.Мөнхгэрэл

Хараат бус гишүүдээр:

1. В.Баттулга
2. Ч.Лундаажанцан
3. Д.Ундармаа

нарыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр баталсугай.

2. Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийг томилон ажиллуулах, цалин урамшуулалыг тогтоохыг ТУЗ-ын хурлаар шийдвэрлэхийг даалгасугай.
3. Компанийг үр ашигтай удирдахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: ..... / В. БАТТУЛГА /



# “ДАВААНБУЛАГ” ХК

2020 оны 04 сар 22 өдөр

№ 20/5

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн ТУЗ болон Гүйцэтгэх  
удирдлагын зардлын төсөв батлах тухай*

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ болон ГУ-ийн 2020 оны үйл ажиллагааны төсвийг 13,440,000 төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА: ..... / В. БАТТУЛГА /

